



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 304

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, журам”-ын 5.1, 5.2, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяа Баянгол, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 31,388,000,00 (гучин нэгэн сая гурван зуун наян найман мянган) төгрөгийн балансын үнэ, 18,997,262.23 (арван найман сая есөн зуун ерэн долоон мянга хоёр зуун жаран хоёр төгрөг хорин гурван мөнгө) хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны Шүүхийн Тамгын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Лүндэндорж, Баянгол, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын дарга Н.Батхүү, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны Шүүхийн Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Санчир нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалт
2019 оны 07 дугаар сарын 24-ны өдөр
304 дугаар тогтоолын хавсралт



БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН

Мөнгө шилжүүлэх байгууллага	Хөрөнгийн нэр, Улсын дугаар, Арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Шилж бай
				(төгрөг)			
Хан-Уул дүүргийн Иргэний анхан шатны Тамгын газар	Хьюндай Соната-7, 03-56 УНУ, КМНЕВ41ВАСА412493, Суудлын автомашин	2012/2012	78460	31,388,000.00	18,997,262.23	12,390,737.77	Сонги дүүргийн хэрэг шатны Тамгын газар
НИЙТ ДҮН				31,388,000.00	18,997,262.23	12,390,737.77	
				(гучин нэгэн сая гурван зуун наян найман мянга)	(арван найман сая есөн зуун ерэн долоон мянга хоёр зуун жаран хоёр төгрөг хорин гурван мөнгө)	(арван хоёр сая гурван мянга долоон зуун гурван төгрөг далан долоон мянга)	